



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 27/448

Арвайхээр сум

Ажлын хэсэг томилж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн "Жагсаалт, журам батлах тухай" 266 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын онцгой комисс, Мал эмнэлгийн ерөнхий газраас ирсэн ажлын хэсгээс тавьсан шаардлагын дагуу мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчний дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Онцгой комиссын гишүүдээр ахлуулсан 7 ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, шаардлагатай санхүүжилтийн тооцоог 2 дугаар хавсралтаар баталж, 2023 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс 07 дугаар сарын 05-ны өдрийг дуустал ажлын гүйцэтгэл сул байгаа 12 суманд ажиллуулахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

2. Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчний дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэх ажлын хэсгийн томилолт, шатахууны зардал 3,431,000 (гурван сая дөрвөн зуун гучин нэгэн мянга) төгрөгийг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3. Бог малын мялзан өвчний дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлж, ажлын хэсгээс заасан хугацаанд бүрэн хийж дуусгахыг сумын Засаг дарга нарт, дархлаажуулалтын ажлын явц, үр дүнд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж, дүнг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн дотор танилцуулахыг Мал эмнэлгийн газар (А.Нямдаваа)-т тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ

6223 11 0878

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 7/448 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Д/д	Хариуцан ажиллах сум	Ажлын хэсгийн ахлагч	Мал эмнэлгийн газраас ажиллах мэргэжилтэн	Хүнс, хөдөө аж ахуйн газраас ажиллах мэргэжилтэн	Жолооч
1.	Богд, Баруунбаян-Улаан сум	Аймгийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа Д.Одонбаяр	Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Б.Ариунцэцэг	Мал үржлийн албаны дарга Б.Цэнгэл	Г.Мягмарсүрэн
2.	Бат-Өлзий сум	Цагдаагийн газрын дарга, хурандаа Г.Чимэддагва	Мэргэжилтэн Т.Оюун-Эрдэнэ	Мэргэжилтэн С.Бат-Эрдэнэ	Х.Данцадмид
3.	Бүрд, Есөнзүйл сум	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга С.Цэдэнбалжир	Мэргэжилтэн С.Саранцэцэг	-	Ч.Чинзориг
4.	Уянга, Тарагт сум	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга, хурандаа Ч.Хүрэлбаатар	Мэргэжилтэн Л.Оюунжаргал	Мэргэжилтэн Б.Иш	Л.Батцэрэн
5.	Нарийнтээл, Хайрхандулаан сум	Эрүүл мэндийн газрын дарга Д.Шивааннүрдэв	Лабораторийн эрхлэгч Х.Мөнхцэцэг	Мэргэжилтэн Ж.Энхтуяа	П.Сундуйбанзраг ч
6.	Зүүнбаян-Улаан, Хужирт, Хархорин сум	Мал эмнэлгийн газрын дарга А.Нямдаваа	Мэргэжилтэн Н.Шийлэгдулам	Мэргэжилтэн Т.Долгормаа	Б.Жаргалсайхан
7.	Сумдын хяналтаар	Засаг даргын орлогч И.Доржсүрэн	Мал, амьтны эрүүл мэндийн албаны даргын үгийг түр орлон гүйцэтгэгч А.Энхтүвшин	-	С.Лхагвацэрэн

Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 14 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ШААРДЛАГАТАЙ САНХҮҮЖИЛТИЙН ТООЦОО

Автомашин (шатахуун)	Ажиллах албан хаагчийн тоо	Хэмжих нэгж	Үнэ	Тоо хэмжээ	Хоног	Нийт дүн
1. Хархорин, Хужирт						
Ланд-76 ӨВО 90-90 Шатахуун (Түлш)	3	л	3660	80	3	292,800
Томилолт	4	Хүн/өдөр	24000	-	3	288,000
2. Баруунбаян-Улаан, Богд						
Ланд-200 ӨВА 01-01 Шатахуун (А92)	3	л	2470	100	3	247,000
Томилолт	4	Хүн/өдөр	24000	-	3	288,000
3. Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий						
Ланд-200 ӨВА 00-02 Шатахуун (Түлш)	3	л	3660	60	3	219,600
Томилолт	4	Хүн/өдөр	24000	-	3	288,000
4. Бүрд, Есөнзүйл						
Ланд-200 ӨВО 02-00 Шатахуун (А92)	3	л	2470	70	3	172,900
Томилолт	3	Хүн/өдөр	24000	-	3	216,000
5. Уянга, Тарагт						
Фургон ӨВР 17-86 Шатахуун (А92)	3	л	2470	50	3	123,500
Томилолт	4	Хүн/өдөр	24000	-	3	288,000
6. Нарийнтээл, Хайрхандулаан						
Ниссан патруль ӨВО 99-93 Шатахуун (Түлш)	3	л	3660	70	3	256,200
Томилолт	4	Хүн/өдөр	24000	-	3	288,000
7. Хяналт						
Ланд-200 ӨВЕ 06-55 Шатахуун (А92)	3	л	2470	100	3	247,000
Томилолт	3	Хүн/өдөр	24000	-	3	216,000
Томилолтын зардал						1,872,000
Шатахууны зардал						1,559,000
Нийт дүн						3,431,000